



ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Монгол Улсын Их Сургууль , Шинжлэх ухааны сургууль

Хөтөлбөрийн нэр: “ Философи “

Индекс: D022301

Шинжээчийн баг:

Ахлагч: Ш.Ариунаа . Шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор
Монгол Улсын Консерваторийн Сургалт, эрдэм
шинжилгээ эрхэлсэн дэд захирал

Гишүүд: Д.Зоригт . (Ph.D) доктор, профессор
“Идэр” их сургуулийн захирал

Т.Нэмэхжаргал (Ph.D) доктор, профессор
МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн
Нийгмийн ухааны тэнхимийн эрхлэгч

2021.12.13

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн	Монгол Улсын Их Сургууль , Шинжлэх ухааны сургууль	
Хөтөлбөрийн нэр, индекс	“ Философи” D022301	
Шинжээчид	<p>Ахлагч: Ш.Ариунаа . Шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор Монгол Улсын Консерваторийн Сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал</p> <p>Гишүүд: Д.Зоригт доктор(Ph.D) профессор “Идэр” их сургуулийн захирал</p> <p>Т.Нэмэхжаргал доктор(Ph.D), профессор МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн эрхлэгч</p>	
Зохицуулагч	Б.Оюунцэцэг	
Төлөвлөгөө	Өдөр	Хийгдсэн байх ажлууд
	2021.09.10	Мэргэжилтэн шинжээчдэд ӨҮТ-г хүлээлгэн өгөх
	2021.09.15	Шинжээчийн урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд өгөх
	2021.09.21	Сургуулийн бэлэн байдлыг нягтлах
	2021.09.23-24	Шинжээчид сургууль дээр ажиллах
	2021.12.13	Шинжээчид магадлан итгэмжлэлд орж буй сургуульд шинжээчийн тайланг илгээх
	2021.12.22	Сургууль шинжээчийн тайлантай танилцаж хариу өгч, шинжээчийн тайлан эцсийн байдлаар бэлэн болох
		Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр гарах
Шалгуур шаардлага	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2016 оны 03 дугаар сарын 15-ний өдрийн 001 дугаар тогтоолоор батлагдсан “Шалгуур, шаардлага шинэчлэн батлах тухай” тогтоолын Хоёрдугаар хавсралтаар батлагдсан шалгуур шаардлагын дагуу ажиллав.	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

МУИС-д 1965 онд философийн салбар нээгдсэнээс хойш хичээлийн жил бүр “философич, нийгэм судлалын багш” мэргэжлээр элсэлт авч, төгсгөж ирсэн.

Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнууд багш төвтэй сургалтаас суралцагч төвтэй сургалтанд шилжих, суралцахуйн үр дүнг суралцагчдын эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагаар үнэлэх, зөвхөн онолын мэдлэг олгох бус практик ур чадварыг онолтой хослуулах, төсөлд буюу асуудалд суурилсан сургалтаар дамжуулан суралцагчдад багаар ажиллах, харилцааны болон үйл ажиллагаа, систем бий болгох чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн технологи, арга зүйг дээд боловсролын сургалтын системд эрчимтэй нэвтрүүлж байна. Философи бакалаврын хөтөлбөр нь философийн чиглэлийн эрдэм шинжилгээ, сургалтын нэгдлийг хангаж, мэдлэгт суурилсан нийгэмд өрсөлдөх чадвартай, мэдлэг, чадвар, дадал, хандлага бүхий философич мэргэжилтэн бэлтгэх зорилготой.

Тус хөтөлбөрт суралцсанаар нийгмийн оюуны үйлдвэрлэлийг хангадаг аливаа салбарт хөрвөн ажиллах сэтгэлгээний цогц чадваруудыг эзэмшдэг. Философи мэргэжлээр төгсөгч бүх шатны сургалтын байгууллага, судалгаа шинжилгээний байгууллага, төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагад багшлах, эрдэм шинжилгээний болон бусад удирдах болон гүйцэтгэх түвшний ажил хийх боловсрол, сэтгэлгээний ур чадвар, хандлагатай болдог.

Философийн тэнхимийн хамт олон 2014-2015 оны МУИС-ийн хөтөлбөрийн өөрчлөлтийн хүрээнд дэлхийд эхний 100-д ордог зарим их сургуулийн Философи хөтөлбөрүүдийг харьцуулан судалж, философи хөтөлбөрийн үндэслэл, хүрэх үр дүн, төгсөгчдийн эзэмшвэл зохих цогц чадамж(компетенци) болон сургалтын хөтөлбөрийн ерөнхий суурь, мэргэжлийн заавал болон сонгон судлах, чөлөөт сонголтын хичээлүүдийн ерөнхий бүтцийг гарган, хичээл тус бүрийн төлөвлөгөөг тодорхойлсон байна. Тухайлбал, АНУ-ын Стэнфордын Их Сургууль, Өмнөд Каролинагийн Их Сургууль, Нью-Йоркийн Их Сургууль, Принстоны Их Сургууль, Колумбын Их Сургууль, Калифорнийн Их Сургууль (Беркли), ИБУИНВУ-ын Оксфордын Их Сургууль, Япон улсын Токиогийн Их Сургууль, Софийн Их Сургууль зэрэг их сургуулийн Философийн тэнхимийн сургалт, судалгааны үйл ажиллагаатай танилцан, хөтөлбөрийн ач холбогдол, үндэслэл, хичээл тус бүрийн төлөвлөгөө, агуулгын харьцуулалт хийсний үндсэн дээр одоогийг мөрдөж байгаа сургалтын төлөвлөгөөг боловсруулан МУИС-ийн ХЕХ-оор 2015 онд батлуулсан.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Философи мэдэлгийн нийгэмд гүйцэтгэх үүргийн дагуу тухайн хөтөлбөрийн дээд боловсролын салбарт гүйцэтгэх үүргийг илэрхийлсэн.
- Философийн хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага, онцлогийг тодорхойлсон.
- Боловсролын салбарт гарч байгаа арга зүйн шинэчлэл өөрчлөлт, ажил олгогчдын захиалга, эрэлт хэрэгцээнд уялдуулан хувь хүний бүтээлч, шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэхэд философийн хөтөлбөрийн үүрэг, ач холбогдлыг 6 хичээлийн жишээн дээр харуулсан.
- 2014-2015 онд сургалтын төлөвлөгөөний агуулгад шинэчлэл хийхдээ АНУ-ын Принстоны их сургууль, Корнелийн их сургууль, Английн эдийн засаг, улс төрийн шинжлэх ухааны коллеж зэрэг гадаадын зарим их сургууль, коллежийн бакалаврын түвшний философийн сургалтын хөтөлбөрүүдийг харьцуулан судалж, баримжаа болгосон.

Онцлог/Туршлага:

- Монгол улсын хөтөлбөрийн эрх зүйн баримт бичгүүд болон МУИС-ийн түвшинд сургалтын хөтөлбөрийг хэрхэн төлөвлөж, боловсруулах чиглэлийг баримтлан хөтөлбөрийг шинэчлэн баталж хэрэгжүүлж ирсэн байна.
- Либерал арт боловсролын гол үнэт зүйлсийг нь хөтөлбөрт тусгасан байна.

Зөвлөмж:

Нийгэм, эдийн засаг, технологийн шинэчлэл, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээний шинжилгээг магадлан итгэмжлэлийн шалгуурын дагуу бүрэн хийх, суралцагч, төгсөгчдийн санал зөвлөмжийг тусгах

Шаардлага:

Хичээлийн жагсаалт батлах тухай боловсролын сайдын А/174 тушаалд үндэслэн гаргасан А/262 тоот тушаалыг хэрэгжүүлэх

Шалгуурыг хангасан байдал: хэсэгчлэн хангасан

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн зорилго, зорилт МУИС-ийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйл, үйл ажиллагааны үндсэн зарчмуудад уялдсан.
- Хөтөлбөрийн зорилго, зорилтуудад үндэслэн суралтаар эзэмших цогц чадамжийг 8 үзүүлэтээр тодорхойлсон, ингэхдээ либераль арт боловсролын

- чадваруудыг эзэмших гол арга замыг философийг судлах явдал гэж үзэж удирдамж болгосон
- МУИС-ийн вебсайт болон SISI сургалтын удирдлагын системээр дамжуулан хөтөлбөрийг олон нийтэд түгээн сурталчилдаг.

Онцлог/Туршлага:

- Марксист-ленинист онолын үндэс, улс төрийн намын сурталд гол төлөв баримжаалж ирсэн хөтөлбөрийг нийгэм, хүмүүнлэгийн ухааны бусад салбаруудын онол, арга зүйн үндэслэл баримжаатай болгож, хөтөлбөрийн шинэчлэлийг хийсэн байна.

Зөвлөмж:

- Хөтөлбөрөөр эзэмших цогц чадамжийг эргэн харж нягтлах, дэлгэрүүлэн оновчлох, мэдлэг, чадвар, хандлагыг ялган тодорхойлох ,
- Хөтөлбөрийн зорилго, зорилт өнөөгийн нийгэм, хувь хүний хэрэгцээ шаардлага болон ШУА-ийн Философийн хүрээлэн болон судалгааны байгууллагуудын зорилго, зорилт, ажлын байрны тодорхойлолт зэрэгтэй хэрхэн уялдаж байгаа гэх мэтээр шинжилж тасралтгүй тасралтгүй сайжруулж байх

Шаардлага:

- Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэх зорилтууд болон хөтөлбөрийн сургалтын нийт хугацаанд эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг тодорхой томъёолох

Шалгуурыг хангасан байдал: хэсэгчлэн хангасан

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Монгол улсад философийн мэргэжлийн сургалт, судалгааны ажлыг явуулж ирсэн онцлогийг судлан, хичээлийн нэршил, агуулга, бүтцэд өөрчлөлт оруулсан
- Философийн сургалт, арга зүйн асуудлаар олон улсын туршлагыг судалсан
- Боловсролын талаар төрөөс баримтлах бодлого, эрх зүйн баримт бичгүүд болон МУИС-ийн сургалтын сургалтын журамд нийцүүлэн шинэлэг, агуулга, арга зүй бүхий хөтөлбөрийг боловсруулан 2017 онд баталгаажуулсан.
- Сургалтын хөтөлбөрт чөлөөт сонголтоор МУИС-ийн бусад сургууль, тэнхимээс хичээл сонгох боломжийг бүрдүүлсэн

Онцлог/Туршлага:

- Философийн сургалт, судалгааны асуудлаар олон улсын байгууллагуудтай хамтран ажилладаг.

- Монгол улсад философийн мэргэжлийн сургалт, судалгааны ажлыг зохион байгуулж ирсэн онцлог, өнөөгийн нөхцөл байдал, шинэчлэлийн асуудлаар улсын хэмжээний симпозиум, зөвлөгөөн, семинарыг зохион байгуулах, үндэсний хэмжээний философийн хөтөлбөрийн шинэчлэлийн чиглэлийг тодорхойлох, зөвлөмж боловсруулах тал дээр анхаарч ажилладаг.

Зөвлөмж:

- Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүд ба суралцахуйн үр дүнгүүд хоорондын хамаарлын зураглалыг бүрэн зөв хийж, үр дүнг хөтөлбөрийг саужруулахад тусгадаг байх

Шалгуурыг хангасан байдал: /Бүрэн хангасан/

1-р шалгуурын талаарх эцсийн үнэлгээ: *Хэсэгчлэн хангасан*

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн код, кредит задаргаа, заавал судлах, сонгон судлах хэлбэр, судлах улирлыг тодорхой тусгасан төлөвлөгөө боловсруулсан.
- Хөтөлбөрөөр 120 кредит судлахаар төлөвлөгдсөн бөгөөд оюутны нэг улиралд багц цагийн хэлбэлзлийг тодорхой зааж өгсөн.
- Нийт судлах кредит цагийн 36 кредит буюу 30% нь ерөнхий суурь, 9 кредит буюу 7,5% нь мэргэжлийн суурь, 60 кредит буюу 50% нь мэргэжлийн хичээл мөн чөлөөт сонголтын зарчмаар бусад салбар сургуулийн хөтөлбөрүүдээс, философийн ерөнхий суурь болон мэргэшлийн хичээлүүдээс сонгох боломжтой 15 кредит буюу 12,5% тус тус байна. Нийт судлах багц цагт мэргэжлийн хичээл 50%-аас их байхаар төлөвлөсөн нь А/174 тушаалд заасан шаардлагад нийцэж байна.
- Оюутны хичээл сонгох боломжийг харьцангуй сайн бүрдүүлсэн, тус хөтөлбөрийг судалж дуусах хугацаа уян хатан зохицуулагдсан.
- Хичээлүүдийн сонгогдож буй байдалд дүн шинжилгээ хийсэн.
- Удирдлага мэдээллийн SISI систем ашиглан оюутнууд хичээл сонгох, суралцах боломж бүрдсэн.
- Сургалт дахь онол, практикийн харьцаа 2/2 цаг байна.
- Үйлдвэрлэлийн дадлагын зорилго үр дүнд дүн шинжилгээ хийсэн.

Онцлог/Туршлага:

- Оюутан ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлийн хүрээнд хичээл, багшийн сонгох боломж бүрджээ.

Зөвлөмж:

- Хөтөлбөр дэх хичээл хоорондын хамаарлыг харуулсан зураглалыг нарийвчлан хийж, дүн шинжилгээ хийх
- Оюутны цагийн ачааллыг улирал, 7 хоног, өдрөөр тооцоолон гаргаж сургалтын төлөвлөгөөнд оюутны цагийн ачааллыг оновчтой харгалзсан эсэхэд дүн шинжилгээ хийх,
- Хөтөлбөрийн хүрэх үр дүн болон хөтөлбөрт баримжаа болгож буй либерал арт боловсролын үнэт зүйлсийг харгалзан үзэж бүх хичээлийн онол практикийн харьцаа 2/2 байгааг эргэн нягталж, зохистой харьцаанд оруулах

Шалгуурыг хангасан байдал: /Бүрэн хангасан/

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Арга зүй нь хичээлийн зорилгыг хангахад чиглэсэн, агуулгад тохирсон, сурах үйл явцыг дэмжихэд чиглэсэн суралцагч төвтэй.
- Семинарын хичээлд гол төлөв харилцан ярилцах, мэтгэлцэх, асуудал дэвшүүлэх, бодлого, дасгал ажиллах, эх зохиол дээр ажиллах, илтгэл хэлэлцүүлэх, эсээ бичих, онолуудад харьцуулалт хийх, кино хичээл, тохиолдол шинжлэх аргуудыг ашигладаг.
- Лекцийн хичээлд хэвлэгдээгүй, нийтийн хүртээл болоогүй мэдээллийг өгөх, эвлүүлгийн арга ашиглах, асуулт хариулт өрнүүлэх, үзүүлэн үзүүлэх зэргээр гэх зэргээр оюутны оролцоог дэмжсэн аргуудыг хэрэглэдэг.
- Багш бүр заадаг хичээлээрээ цахим контенттай болсон.

Онцлог/Туршлага:

- Оюутан хичээлд бэлтгэх номын сангийн үйлчилгээ, хүртээмж сайн, анги танхим бүр проектор, компьютер, ухаалаг индэр, самбартай болсон.

Зөвлөмж:

- Сургалтад ашиглаж байгаа дээрх аргуудын аль нь ямар хичээлд тохирч байгаад үнэлэлт дүгнэлт өгч ажиллах
- Ихэнх хичээлийн хувьд тухайн хичээлээр эзэмших мэдлэг, чадвар хандлагыг тодорхойлсон нь хэт ерөнхий байгааг анхааран хичээлийн агуулгад нийцүүлэн оновчтой болгох
- Оюутны бие даан гүйцэтгэх ажлын талаар хөтөлбөрт тусгах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан /**2.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн ерөнхий суурь хичээл, мэргэжлийн суурь хичээл, мэргэжлийн хичээлүүдийн дүнгийн тархалт, төгсөгчдийн сурлагын амжилт, дундаж үзүүлэлт, голч дүнд сүүлийн 5 жилээр шинжилгээ хийж, зохих дүгнэлтийг хийсэн.
- Үнэлгээний хэлбэр, жин МУИС-ийн сургалтын журмын дагуу явагддаг.
- Оюутны сэтгэл ханамжийн судалгаанд сүүлийн 5 жилээр дүн шинжилгээ хийсэн.
- Багш нар үнэлгээний даалгаврын сантай

Онцлог/Туршлага:

- Суралцагчдын дүнгийн тархалт, амжилт, голч дүн, оюутны зүгээс хөтөлбөрийн хэрэгжилтэд өгсөн сэтгэл ханамжийн судалгаанд тус тус дэлгэрэнгүй шинжилгээ хийсэн байна.

Зөвлөмж:

- Үнэлгээний санг тухайн хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, хандлагад нийцүүлэн боловсруулах
- Хичээл бүрийн хөтөлбөрт үнэлэх арга зүй, шалгуурыг тусгах

Шаардлага:

- Оюутны бие даан гүйцэтгэх ажлын хэлбэр, агуулга, аргачлал тодорхойгүй, зарим хичээлийн хөтөлбөрт бие даан гүйцэтгэх ажлын үнэлгээ нь явцын үнэлгээнд багтсан, зарим хичээлд тусдаа үнэлгээний жинтэй, зарим хөтөлбөрт энэ талаар огт дурдагдаагүй, кредитийн задаргаанд долоо хоногт бие даалтын ажилд зарцуулах цаг тусгагдаагүй зэрэг тодорхойгүй байдлыг анхаарч, жигдлэн сайжруулах

Шалгуурыг хангасан байдал: / хэсэгчлэн хангасан, /

2-р шалгуурын талаарх эцсийн үнэлгээ: *Бүрэн хангасан*

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Номын сангийн шинэ байр 2017 онд ашиглалтад орсон. 700 гаруй суудалтай, утасгүй сүлжээнд бүрэн хамрагдсан.
- Лекц, семинарын бүх танхимд алсын удирдлагатай проектор, дэлгэц, ухаалаг индэр, компьютер, интернет зэрэг мэдээллийн технологийн орчин нөхцөлийг бүрдүүлж өгсөн байна.
- Багш нарын өрөө нь шаардлагатай тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгслээр бүрэн хангагджээ.
- ФШСТ-ээс хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд 2014 оноос хойш 211 тоот өрөөнд 2070400, 218 тоот өрөөнд 4.787.969 төгрөгийн санхүүжилт тус тус хийгджээ.

Онцлог/Туршлага:

- 2020 онд МУИС-ийн ШУС-иас хичээлийн 2-р байрны нийт 50 анги танхим 4 ариун цэврийн өрөөг бүрэн засварлаж, барилгын зүүн талын гадна фасадны хэсгийг засаж сайжруулсан. Нийт анги танхимын 40 хувьд засвар хийсэн ба байрны дулааны өгөх, буцах шугамыг бүрэн сольж, засварласан байна.
- Office 365 цахим шуудангийн үйлчилгээг Сиси мэдээллийн системтэй холбосон явдал бөгөөд оюутан бүрт автоматаар цахим шуудангийн хаяг үүсгэж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна.

Зөвлөмж:

- “Философи” –хөтөлбөрөөр суралцагсдын хичээллэх анги танхимын тоог нэмэгдүүлэх
- Сургалтын орчны тохижилтыг сайжруулах
Оюутны сэтгэл ханамжийн судалгаа, болон бодит нөхцөлд дүн шинжилгээ хийж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллах

Шалгуурыг хангасан байдал: *Бүрэн хангасан*

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Багш нар нь судалгааны ажлын чиглэлийн дагуу нэгэн сэдэвт ном, сурах бичиг, гарын авлага, орчуулгын бүтээлүүд хэвлүүлсэн байгааг үзэж танилцав.
- “Багшийн хөгжил, цахим сургалтын төв” /БХЦСТ/-ийг шинээр байгуулсан байна.
- Багш нарын цахим хичээл бэлтгэх, зохион байгуулах үйл ажиллагааг зохицуулах журам батлан мөрдөж байна.
- МУИС-ийн захирлын 2020 оны 4 дүгээр сарын 20-ны А/89 тоот тушаалаар баталсан “Цахим сургалтын түр журам”-д заасан хичээлийн багц материалыг багш нар боловсруулжээ.

Онцлог/Туршлага:

- Багш нарын бичиж хэвлүүлсэн мэргэжлийн нэгэн сэдэвт бүтээлүүдийг Монголын нийгэм, хүмүүнлэгийн ухааны салбарын сургалт, судалгаанд өргөнөөр ашиглаж байна.
- Багш нар философийн эх зохиол, бусад бүтээлүүдийг орчуулах ажлыг бие дааж болон хамтарч хийсэн байна.

Зөвлөмж:

1. Шаардлагатай ном, сурах бичгийг нэмэгдүүлэх талаар үе шаттай арга хэмжээг төлөвлөн ажиллах
2. Цахим хичээлийн агуулгын төлөвлөгөө, стандарт боловсруулж ажиллах болгон бэлтгэх, зохион байгуулах

Шалгуурыг хангасан байдал: *Бүрэн хангасан*

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- 2017 онд ашиглалтад орсон МУИС-ийн номын сангийн шинэ байр нь чөлөөт сонголттой уншлагын танхим, гэрээр ном олгох фонд, нэг цэгийн үйлчилгээ, тогтмол хэвлэлийн уншлагын танхим зэрэг 15 цэг салбарт 700 гаруй суудлын багтаамжтайгаар үйлчилгээ үзүүлж байгааг үзэж танилцлаа.
- МУИС-ийн номын сан нь 2020-2021 оны хичээлийн жилийн байдлаар 390,000 гаруй хэвлэмэл болон цахим бүтээлийн сан хөмрөгтэй, олон улсын онлайн мэдээллийн санг ашиглах боломжийг бүрдүүлэн уншигчдад үйлчилж байна.
- Оюутнууд цахим сүлжээнд бүрэн холбогдсон ба бүлгээр ажиллах өрөөг урьдчилан захиалж бие даан болон багаар ажиллах боломжийг бүрдүүлжээ.

- Тэнхим нь хэрэгжүүлж буй хоёр хөтөлбөрөөрөө номын сантай болж, жил бүрийн төсөвт ном, сурах бичиг худалдан авах зардал суулган, баяжуулжээ.
- Одоогоор философийн хөтөлбөрийн номын санд нийт 1860 ном, сурах бичиг байна.
- Философи, шашин судлал мэргэжлийн сэтгүүлийн нийт 19 дугаарын 432 өгүүллийн түлхүүр үг, хураангуйг цахим хаягт <http://prslibrary.librarika.com> сайт үүсгэн оруулсан.
- Салбар сургуулаас эрхлэн гаргаж байсан “Эрдэм шинжилгээний бичиг”-ийн бүх дугаарын агуулгыг цахимжуулсан.

Онцлог/Туршлага:

- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний өгүүлэл татах системд хандах эрхийг нь авч ашиглах боломжтой байна.
- Багш, суралцагч нар МУИС-ийн сүлжээнээс https://library.num.edu.mn/?page_id=3987 сайтаар хандан гадаадын 16 онлайн мэдээллийн санг ашиглаж байгаа юм байна.
- Хичээлийн жил бүр “Багш ажилтныг дэмжих сан”-аас санхүүжилт /жилд 5500000 төгрөг/ авч, тодорхой хувийг мэргэжлийн ном, сурах бичиг худалдан авахад зориулж иржээ.
- “Философи” хөтөлбөрийн IY курсын оюутнууд үйлдвэрлэлийн дадлагын хүрээнд тэнхимийн монгол болон орос, англи хэл дээрх мэргэжлийн сэтгүүлүүдийн контентыг цахимжуулан бүртгэж, мэдээллийн сан бүрдүүлэн, сургалт, судалгаанд ашиглах боломжтой болгожээ.

Зөвлөмж:

- Хөтөлбөрөөр ашиглах гадаад эх сурвалжийг нэмэгдүүлэх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо: Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд үйл ажиллагаандаа мөрдлөг болгодог МУИС-ийн дүрэм, журмыг үзэж танилцав.

1. “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай”, БСШУСЯ-ны сайдын 2014.03.13-ны өдрийн А/78 тоот тушаал;
2. “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”, БСШУСЯ-ны сайдын 2014.04.28-ны өдрийн А/174 тоот тушаал;

3. “МУИС-ийн дүрэм”, МУИС-ийн удирдах зөвлөлийн 2017.06.14-ний өдрийн 08 тоот тогтоол. “МУИС-ийн Дүрэмд өөрчлөлт оруулах тухай” МУИС-ийн удирдах зөвлөлийн 2019.03.22-ний өдрийн 02 тоот тогтоол;
4. “МУИС-ийн Сургалтын журам”, МУИС-ийн захирлын 2015.06.30-ны өдрийн А/203 тоот тушаал;
5. “МУИС-ийн Хөтөлбөрийн хорооны журам”, МУИС-ийн захирлын 2016.12.23-ны өдрийн А/347 тоот тушаал;
6. “МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт оюутан элсүүлэх журам”; (жил бүрийн);
7. “МУИС-д суралцагч шилжүүлэн суралцуулах журам”, МУИС-ийн захирлын 2019.11.14-ний А/483 тоот тушаал;
8. “МУИС-д технологийн коллеж төгсөгчийг суралцуулах түр журам”, МУИС-ийн захирлын 2019.08.27-ны өдрийн А/359 тоот тушаал;
9. “Бакалаврын түвшний оюутны мэргэжлийн хөтөлбөр сонгох журам”, МУИС-ийн захирлын 2019.10.28-ны өдрийн А/462 тоот тушаал;
10. “МУИС-ийн суралцагчийн дадлагын журам”, МУИС-ийн захирлын 2018.04.26-ны өдрийн А/136 тоот тушаал;
11. “МУИС-д хичээл дүйцүүлэх журам”, МУИС-ийн захирлын 2019.11.18-ны өдрийн захирлын А/495 тоот тушаал;
12. Бакалаврын сургалтын хөтөлбөр боловсруулах удирдамж

Эдгээр журмуудыг нийтэд нээлттэй МУИС-ийн вебсайтад <https://www.num.edu.mn/content.htm?mid=399> хаягаар байршуулсан байна.

Онцлог/Туршлага:

- МУИС-ийн сургалтын мэдээллийн SISI систем нь МУИС-ийн сургалт, удирдлага, зохион байгуулалттай холбоотой үйл ажиллагааг хөнгөвчлөх, чанаржуулах, шуурхай, найдвартай, ил тод, хяналттай болгох зорилготой вэб-д суурилсан сургалтын мэдээллийн систем байна.
- Элсэх, шилжих, төгсөх, мэргэжлийн хөтөлбөр сонгох, дүгнэх сургалтын үйл ажиллагаа нь сургалтын мэдээллийн SISI системээр явагдаж байна.
- МУИС нь 2015 онд сургалтын бүх хөтөлбөрөө шинэчлэн боловсруулж шат шатны хөтөлбөрийн хороодоор хэлэлцүүлэн батлуулжээ.
- Философи Шашин судлалын тэнхим нь 5 хүний бүрэлдэхүүнтэй ТХДХ-той байна. (2018,2021 онуудад бүрэлдхүүнийг шинэчлэн баталсан)
- МУИС-ийн Стратеги төлөвлөгөө 2016-2024-нд МУИС нь дэлхийн түвшний их сургууль болох хэтийн зорилгыг дэвшүүлсэн ажээ.

Зөвлөмж:

- Тэнхмийн ажлын төлөвлөгөөнд тусгаж , хөтөлбөрийн зорилгын тухай хэлэлцүүлэг зохион байгуулж ажиллах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

Тэнхим нь дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож, хамтран ажилладаг байна. Үүнд: **Дотоодын:**

- ШУА-ийн Философийн хүрээлэн, Боловсролын Хүрээлэн,
- МУ-ын Засгийн газрын дэргэдэх Жендэрийн Үндэсний хороо, Жендэрийн консорциум,
- ШУТИС-ийн БУХС, МУБИС-ийн НХУС,
- Хүний эрхийн олон улсын Эмнести Интернэшл байгууллага, “
- Философийн салбарыг төгсөгчдийн холбоо”, Соёл судлаачдын холбоо,
- Зохистой хөгжил жендэр төв, Монголын Буддын судлалын хүрээлэн
- **Гадаадын:**
- Азийн философичдын Холбоо,
- БНГУ-ын Чөлөөт Берлины Их Сургууль,
- АНУ-ын Канисиус Их Сургууль,
- БНХАУ-ын Бээжингийн Их Сургууль,
- БНСУ-ын Дэгү Их Сургууль,
- Японы Отани ИС-ийн Шин Буддын судлалын хүрээлэн,
- БНХАУ-ын ӨМӨЗО-ны Багшийн их сургууль,
- Японы Кокушिकан Их Сургууль, Шукотоку их сургууль, Отани их сургуулийн Шин Буддист судалгааны хүрээлэн,
- Швецарийн Хөгжлийн Агентлаг,
- ХУ-ын Москвагийн Патрис Лумумбийн нэрэмжит улс түмний найрамдлын их сургууль, Саратовын Техникийн Их сургууль, Беларусийн Улсын Их Сургуулийн Философи, шинжлэх ухааны арга зүйн тэнхим

Онцлог/Туршлага:

- ХБНГУ-ын Цитау-Герлитц их сургуулийн профессор, доктор М.Т.Фогт 2017 оны 5 дугаар сард соёлын онол, бодлогын асуудал, европын түүхийн сэдвээр лекц уншиж, хэлэлцүүлэг зохион байгуулсан.
- Профессор Т.Дорждагва профессор Фогтын урилгаар Цитау-Герлицийн их сургуульд 2016 онд зочин судлаачаар 6 сарын хугацаатай ажилласан.
- БНХАУ-ын Шандун их сургуулийн Философи, нийгмийн хөгжлийн сургуулийн профессор Фу Ёнзунь 2018 оны 5 дугаар сард “Эртний Хятадын текстийг тайлбарлахуйн утга холбогдол” сэдвээр лекц уншсан байна.
- Хятад улсын Герменевтикийн мэргэжлийн хороо, Далианий технологийн ИС-ийн Гадаад хэлний сургууль, Шаньдуны ИС-ийн Хятадын герменевтикийн судалгааны төвөөс хамтран зохион байгуулсан "Хүлээн авахуй, хувирахуй, бүтээхүй: Герменевтик ба Хятад улс" сэдэвт герменевтикийн 13 дахь удаагийн олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд /2016 оны 04 дүгээр сарын 23-24/ профессор Г.Лодой, Р.Дарьхүү нар илтгэл бичиж оролцжээ.

- Беларусийн Улсын их сургуулийн Шинжлэх ухааны философи, арга зүйн тэнхмийн эрхлэгч профессор Анатолий Изотович Зеленков “Философия и наука. Метаморфозы диалога” сэдвээр 2019 оны 10 дугаар сард багш, оюутнуудад цуврал лекц уншсан.
- Беларусийн Улсын Их Сургуулийн Философи, шинжлэх ухааны арга зүйн тэнхимтэй 2019 оны 10-р сарын 10-нд харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулж (MOU), гарын үсэн зурсан байна.

Зөвлөмж:

- Хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн хэмжээнд 2014-2015 оны хичээлийн жилээс төсвийн төлөвлөлт, орлого хуваарилалт, бүтээгдэхүүний өртөг тооцооллын шинэ журамд шилжин ажиллаж байна.
- Төсвийн хөрөнгөөр хийгдэх ажлуудыг тэнхимийн жил бүрийн ажлын төлөвлөгөөнд нарийвчлан тусгаж хэрэгжүүлж байна.
- МУИС-ийн хөгжлийн сан, “Багш дэмжих хөтөлбөр” нь эрдэм шинжилгээ судалгаа, төсөлт ажил, гадаад арга хэмжээний зардлыг санхүүжилдэг ажээ.
- МУИС-аас 2016-2020 онд ФШСТ-ийн багш нарыг дэмжих зардалд нийт 26,700,000 төгрөг олгожээ.
- Багшийн хөгжлийг дэмжиж сүүлийн 5 жил 26,7 сая төгрөг зарцуулсан байна.

Онцлог/Туршлага:

Тэнхмийн хамт олон улсын болон дотоодын байгууллагатай хамтарсан төсөл хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- ШУТСангийн санхүүжилтээр хэрэгжсэн “Залуучуудын химийн болоод химийн бус үүдэлтэй донтолыг биеийн тамираар анагаах этноспортын элементүүд” төсөл Б.Дагзмаа
- ШУТС-ийн санхүүжилтээр хэрэгжиж буй Нийгмийн ухаан: техноугшилт иргэншлийн сорилтууд сэдэвт Орос Монголын хамтарсан төсөлд проф Б.Дагзмаа, М.Отгонбаяр, Ц.Нямсүрэн нар /2019-2021/
- ШУА-иас санхүүжүүлж буй “Монголчуудын ан амьтныг хамгаалах уламжлалт зан үйл, ёс заншил ба орчин үе” сэдэвт төсөлд дэд проф Д.Оюунгэрэл /2019-2020/

Зөвлөмж:

Хөтөлбөрийн багш нарын МУИС-ийн ерөнхий суурь болон ХУС-ын мэргэжлийн суурь хичээлүүдийг заасан орлогийг тэнхмийн бодитой орлого болон тооцож, хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувийг багш, суралцагчийн хөгжилд зарцуулдаг эх үүсвэр болгох.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Элсэлтийн үйл ажиллагааг таниулах мэдээллийг хэвлэмэл материал, видео танилцуулга байдлаар Сургалтын нэгдсэн албанаас бэлтгэж МУИС-ийн болоод бусад бүрэлдэхүүн, салбар сургуулиудын цахим хуудас www.num.edu.mn, facebook, телевиз, FM, сонин, сэтгүүл болоод бусад олон нийтийн хэвлэл мэдээлэлийн хэрэгсэл, БСШУСЯ, Аймаг орон нутгийн удирдлагууд, ТББ зэргээр дамжуулан хүргэдэг байна.
- Хөтөлбөр сурталчлах үйл ажиллагааг намар болон хаврын улиралд хоёр удаа зохион байгуулдаг ажээ.
- МУИС-ийн бакалаврын бүх хөтөлбөрийн танилцуулгыг багтаасан “Мэргэжлийн хөтөлбөрийн танилцуулга” номтой
- “Мэргэжлээ хэрхэн сонгох вэ”, “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ”, “Ирээдүйн чиг хандлагыг ойлгох” цуврал уулзалт ярилцлагыг зохион байгуулж зөвлөгөө өгдөг байна.
- Хөтөлбөрийн хөгжлийн төлөвлөгөө байхгүй байна.

Онцлог/Туршлага:

- Улсын хэмжээнд философийн олимпиадыг мэргэжлийн бус оюутны дунд зохион байгуулж уламжлал болгосон байна.
- Дэлхийн философийн өдөрт зориулан эрдэм шинжилгээний хурал зохион байгуулдаг ажээ.

Зөвлөмж:

- Хөтөлбөр маркетингийн төлөвлөгөө боловсруулж ажиллах.
- Хөтөлбөрийн зураглал, түүн дотроо зах зээлийн судалгааг нарийвчлан боловсруулах.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС нь www.num.edu.mn сайтаар дамжуулан бүх мэдээллүүдээ ил тод нээлттэй хүргэдэг байна.
- Бакалаврын хөтөлбөрүүдийн танилцуулга, суралцахуйн зорилтот үр дүн, элсэгчид тавих шаардлага, сургалтын төлөвлөгөөний бүтэц, суралцах ачаалал, багц цаг, суралцахуйн үнэлгээний аргачлал зэрэг мэдээллийг олон нийтэд нээлттэйгээр албан ёсны эх сурвалжаас авах блонжийш бүрдүүлжээ.
- Тэнхмийн цахим хуудсанд хөтөлбөрүүдийн мэдээллийг дэлгэрэнгүйгээр нь байршуулсан байна.

Онцлог/Туршлага:

- МУИС-ийн үндсэн веб сайт болох www.num.edu.mn нь үндсэн цэс, мэдээ мэдээлэл, чухал холбоос, салбар сургуулиудын веб холбоос болон бусад нэгжийн веб холбоос гэсэн бүтэцтэй байна.
- Тэнхмийн <https://www.facebook.com/DPRSNUM> хаяг бүхий facebook –ийн цахим хуудас ажиллуулж байна.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн үйл ажиллагааг бүхэлд нь сурталчлах мэдээллийг тогтмолжуулж, хүртээмжийг сайжруулах ажлыг төлөвлөн хийж гүйцэтгэх.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчдад суралцагчийн тэтгэлэг олгох журам”,
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны 03 дугаар сарын 18-ны А/79 тоот тушаалаар батлагдсан "Оюутан элсүүлэх журам",
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/194 тоот “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тушаал,
- МУИС-ийн захирлын 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/296 дугаар тушаалаар баталсан “[Бакалаврын түвшний оюутны мэргэжлийн хөтөлбөр сонгох журам](#)”

Онцлог/Туршлага:

- МУИС-д элсэгчдийн ЭЕШ-ын дундаж оноо 2016-2020 онд 614 байсан бол ШУС-ийн ХУС-т элсэгчдийнх 619 байжээ.
